

**УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ БУУДАЛ БАРИХ
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЛААР**

2017.02.24-2017.03.10

НЭГ. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/ болон Япон Улсын “Мицүбиши-Чиёода хамтарсан түншлэл хооронд 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал барих барилгын ажлын гэрээ” МОНР8-ын дагуу Ерөнхий гүйцэтгэгч төслийг төлөвлөсөн цаг хугацаа болох 1290 хоногт багтаан амжилттай хэрэгжүүлж, Улсын комисс болон Иргэний нисэхийн ерөнхий газраас өгсөн 01/293 тоот зөвшөөрлийн дагуу тул Зөвлөх компани 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г гаргасан ба тус гэрчилгээнд дор дурдсан барилга байгууламж, дагалдах тоног төхөөрөмжийг 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөр тооцож Захиалагчид шилжүүлсэн болно.

Гэрээний дагуу хүлээн авсан барилга байгууламж, дагалдах тоног төхөөрөмжүүд:

№	Барилга, байгууламжийн нэр
1	Зорчигч үйлчилгээний барилга
2	Усан хангамжийн систем /цэвэр усны байгууламж, гүний худаг/
3	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхаг
4	Хяналтын цамхгийн цахилгааны дэд өртөө
5	Гал унтраах авран хамгаалах албаны барилга
6	Цэвэр усны байгууламж
7	Нисэх буудлын цахилгаан хангамжийн систем /Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга/
8	Дулаан хангамжийн систем /Дулааны зуухны барилга/
9	Глиссадын радио маякын байр
10	Глиссадын радио маякын цахилгааны дэд өртөө
11	Хэт богино долгионы радио нэвтрүүлэх төвийн цахилгааны дэд өртөө
12	Курсын радио маякын байр
13	Курсын радио маякын цахилгааны дэд өртөө
14	Агаарын хөлгийн шатахуун хангамжийн систем, барилга байгууламжууд
15	Талбайн бэлтгэл ажил, газар шорооны ажил, үерийн далан
16	Хөөрч буух зурвас
17	Явгалах зам
18	Перрон
19	Газрын үйлчилгээний тоног төхөөрөмжийн зогсоол, Перроны үйлчилгээний зам

20	Автозам болон авто зогсоол
21	Үйлчилгээний зам
22	Зурвасын гэрэлтүүлэг, Агаарын навигацын систем
23	3 Галын машин, 1 түргэн тусламжийн машин, 1 албаны машин

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 129 албан тоотын хавсралтаар “Ажил хүлээн авсан гэрчилгээ” болон холбогдох материалыг ЗТХЯ-нд хүргүүллээ.

Гүйцэтгэгчид “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г олгосноор “Чанарын баталгаат хугацаа” эхлэх ба 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэлх нэг жилийн хугацаанд Улсын комисс, Техникийн комиссоос өгсөн үүрэг даалгавар болон Гүйцэтгэгчийн гаргасан засварлах ажлын жагсаалтын дагуу гүйцэтгэх ажлуудыг хийх юм.

Улсын комиссын гишүүдийн саналын хуудсанд нийт 1205 санал, зөвлөмж, зөрчил болон дутагдал бичигдсэнээс 691-ийг нь комисс ажиллах хугацаанд засаж залруулсан ба үлдсэн 514 ажлыг Улсын комиссын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу Чанарын баталгаат хугацаанд үе шаттайгаар төлөвлөгөө гарган арилгах буюу зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллахаар болсон юм.

Төслийн зүгээс Улсын комиссоос гаргасан шийдвэртэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газрын Шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх захиргааны алба, Төслийн Зөвлөх компани, Гүйцэтгэгч байгууллага, Төсөл хэрэгжүүлэх нэгж хамтран нийт илэрсэн зөрчил дутагдал, зөвлөмжийг нэгтгэн зүйл тус бүрээр харилцан зөвшилцөж баталгаажуулах арга хэмжээг авлаа.
- Баталгаажсан зөрчил, дутагдал, комиссын гишүүдээс гаргасан зөвлөмжийг нарийвчлан судалж Гүйцэтгэгчийн зардлаар засаж сайжруулах ажлууд, зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай нэмэлт зардлаар гүйцэтгэх ажлууд, шинээр нэмэлтээр хийх ажлууд гэсэн үндсэн 3 бүлэгт ангилан авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзнийг тогтоон төлөвлөгөө гаргахаар ажиллаж байна.
- Засаж сайжруулах ажилд хяналт тавих, гүйцэтгэлийг баталгаажуулах ажлууд төслийн тогтсон процедурын дагуу хэрэгжих бөгөөд Зөвлөх компани тухайн ажлыг баталгаажуулсны дараа Төсөл хэрэгжүүлэх нэгж, Ашиглалтын өмнөх захиргааны алба хамтран шалгаж хэрэгжилтийг тайлагнах замаар ажиллах зохион байгуулалтын шийдлийг тохироод байна.
- Гүйцэтгэгчээс засаж сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилтийг гүйцэтгэгчийн гаргасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 125 албан тоотой хүргүүлсэн.

Улсын комиссын акт баталгаажих хугацаанд дээрх зөрчил, дутагдлын 60 орчим хувь нь засагдсан ба Зөвлөх компани нь Иргэний нисэхийн ерөнхий газартай байгуулсан гэрээний хүрээнд баталгаат хугацааны хяналтыг 2017 оныг дуустал гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд үлдсэн бүх зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж эцсийн тайлан боловсруулах юм.

Мөн зөрчил дутагдал арилгах, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлын явцыг 2017 оны 06 дугаар сард Мэргэжлийн хяналтын ерөнхий газраар шалгуулж удирдамж чиглэл авч ажиллах саналыг уламжилсан билээ.

Захиалагч талд шилжүүлээд буй Үндсэн болон түр барилга байгууламжийн ашиглалт, харуул хамгаалалтыг 2017 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал “Мицүбиши-Чиёода” түншлэл хариуцан ажиллахаар ярилцаж байгаа боловч гэрээний дагуу 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөр Төслийн үндсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн эрсдэлийн асуудал Захиалагч талд шилжээд байна. 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Төслийн талбайн харуул хамгаалалт Чингис хаан Олон улсын нисэх буудлын Аюулгүй байдал, хамгаалалтын албанд шилжсэн ба тус байгууллагын дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд талбайн өдөр тутмын аюулгүй байдлын үйл ажиллагаа хэвийн явагдаж осол, зөрчилгүй ажиллав.

Шинэ нисэх буудалд суурилагдах тоног төхөөрөмж, системийн туршилт тохируулга хийх ажлууд хуваарийн дагуу 100% хэрэгжиж дууссан. Туршилт, тохируулга хийх ажлын аргачлалуудад Иргэний нисэхийн ерөнхий газар, “Чингис хаан” ОУНБ-аас санал авч баталгаажуулж, мөн туршилт, тохируулга хийх ажил болон холбогдох сургалтуудад Иргэний нисэхийн ерөнхий газар, “Чингис хаан” ОУНБ-ын холбогдох инженер, техникийн ажилтнуудыг хуваарийн дагуу хамруулж, туршилт тохируулгын ажлын талаар гаргасан саналыг тусгаж ажиллаа.

Төслийн нэмэлт гэрээнд Монголын талын хүсэлтээр нэмэлт барилга байгууламжийн барилга угсралтын ажил, шатахуун хангамжийн системийн болон газрын үйлчилгээний тоног төхөөрөмж, хүзүүвчинд тоноглогдсон агаарын хөлгийг цахилгаан тэжээлээр хангах төхөөрөмжийг үйлдвэрлэж нийлүүлэх ажил, шугам сүлжээний нэмэлт ажлууд, ландшафт, аэродромын тооцоот ажиглалтын систем /M-LAT/-ийн ажил болон нисэх буудлын хамгаалалтын хашааны угсралтын ажлууд орсон ба уг ажлууд хуваарийн дагуу хэрэгжиж байна.

Агаарын хөлгийн шатахуун хангамжийн системийн хувьд анх Монголын Засгийн газар хэрэгжүүлэх байсан боловч төсөв хүрэлцээгүйн улмаас Гүйцэтгэгчийн ажилд хамаарагдах болсон ба шатахуун дүүргэлтийн ажлыг 4 дүгээр сард эхэлж 2 сарын хугацаанд хийж дуусгах төлөвлөгөөтэй байна.

1. 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 7 хоногийн шуурхай хурал хийж, ажлын явц байдлыг хэлэлцэж цаг хугацаа алдахгүй шийдвэрлэх асуудлын явц байдлыг дүгнэж, тулгамдсан ажлуудыг тодорхойлж ажиллаа.
2. Төсөл хэрэгжүүлэх нэгж, ИНЕГ-ын ашиглалтын өмнөх захиргааны баг 7 хоног тутам хамтарсан хурал хийхээр шийдвэрлэсний дагуу 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ээлжит хурлыг зохион байгуулж тулгамдсан асуудлуудыг хэлэлцэв.
3. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын барилга байгууламжуудыг Улсын комисс хүлээн авч байгаатай холбогдуулан барилгын зураг төсөл, хувийн хэрэг, бусад баримт бичгүүдийг архивын нэгжид хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн түүнчлэн барилга байгууламж, түүнийг дагалдах технологийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, сэлбэг хэрэгслийг тоолж хүлээн авах ажлын хэсэг ИНЕГ-ын даргын 2017 оны 01 сарын 26-ны өдрийн А/56 тоот тушаалаар байгуулагдан, төслийн талбай дээр 2017 оны 02

дугаар сарын 14-ний өдрөөс комиссын гишүүд төслийн инженерүүдийн хамт барилга байгууламж тус бүрээр тооллого хийн, бүртгэх ажил явагдсан. Уг тооллогын ажлыг хийж дуусах хугацааг 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл сунгах саналыг ИНЕГ-аас ирүүлсэн.

4. Япон улсын хөнгөлөлттэй зээлийн үлдэж буй хөрөнгөөс ангарын барилгын ажлыг санхүүжүүлэх боломжийг судлах албан хүсэлтийн дагуу Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын зураг төсөл боловсруулах даалгаварыг хийж, ИНЕГ болон агаарын тээвэрлэгч компаниуд, холбогдох байгууллагуудтай зөвшилцөж шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж байна.

ХОЁР. НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ БУУДЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Барилгын ажилтай зэрэгцэн шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлуудыг ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын техникийн туслалцаагаар 2014 оны 09 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. Нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгж тайлант долоо хоногт дараах ажлуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг болон Японы Консорциум хооронд хийгдсэн эхний шатны гэрээний хэлэлцээгээр талууд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зарим асуудлуудыг дахин судлан, дараагийн шатанд хэлэлцэхээр тогтсон бөгөөд хийх ажлуудыг Ажлын хэсгийн гишүүдэд хуваарилан ажиллаж байна.
- Түүнчлэн шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд JICA байгууллагын Агаарын навигацийн системийн бэлтгэл ажилд туслалцаа үзүүлэх ажлын хэсэг Монголд ирээд байгаа бөгөөд Ашиглалтын өмнөх захиргааны алба болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж шалгалтын нислэгийг хэрхэн зохион байгуулах болон нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай гэрчилгээжүүлэлтийн авах процедурын талаар хэлэлцэв.
- Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, системийн сургалтууд эрчимтэй хэрэгжиж байгаатай холбогдуулан нисэх буудлын холбооны тоног төхөөрөмжийн сулгалтуудын материалыг бэлтгэж дуусаад байгаа бөгөөд холбогдох мэдээллийг Иргэний нисэхийн ерөнхий газрын Ашиглалтын өмнөх захиргааны алба болон “Чингис хаан” ОУНБуудлын инженер техникийн ажилтнуудыг хамруулав.
- Мөн төслийн хүрээнд суурилагдсан систем, тоног төхөөрөмжийн туршилт тохируулгыг хийж Ашиглагчид хүлээлгэн өгөх ажлын хүрээнд шинэ нисэх буудлын агаарын навигаци, цахилгаан, механикийн систем тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлын гүйцэтгэлийн тайлан, ашиглалт, үйл ажиллагааны зааврыг бэлтгэв.
- Төслийн Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй ээлжит уулзалтыг хийж Улаанбаатар хотын Олон улсын

нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээний дагуу нисэх буудлын ашиглагч байгууллагад бэлтгэн өгөх тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагааны заавар г.м баримт бичгүүдийг хүлээлгэн өгөх процедур, зохион байгуулалтын талаар хэлэлцэв.

ГУРАВ. МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХАРИУЦСАН АЖЛУУД

1. Улаанбаатар хотоос Хөшигийн хөндийн нисэх буудал барих газарт 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам татах, дэд станцыг байгуулах

Нийслэл хотын хөрөнгө оруулалтаар баригдах Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа чадалтай Дэд станцын барилга угсралтын ажил саатаж байгаа тул уг ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Уг ажил нь санхүүжилтийн хүндрэлээс үүдэн саатсан тухай мэдээлэлтэй байна. Холбогдох газруудад мэдээлэл хүргүүлэн, асуудлыг шийдвэрлүүлэх талаас хүсэлт илгээсэн. Энэ асуудлыг Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

2. Шинэ нисэх буудлыг Улаанбаатар хоттой холбох хурдны авто замыг барьж байгуулах

Энэ ажил цаг агаарын нөхцөлийн улмаас түр завсарлаж, 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дахин үргэлжлүүлэх шийдвэрт хүрсэн тухай Гүйцэтгэгч БНХАУ-ын “China Tiesiju Civil Engineering” компани 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 147/A16 тоот албан бичгээр бидэнд мэдэгдсэн.

3. Үерийн хамгаалалтын далан

2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төсөл хэрэгжүүлэх нэгж, зохиогчийн хяналт тавин ажилж буй “Гидро-Фонтан” ХХК болон гүйцэтгэгч “Боорчи” ХХК-ийн төлөөллүүд өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу дахин шалгалт хийхэд цэвэрлэгээ хийх, заадас гаргах, далангийн дээд үеийг тэгшлэх зэрэг ажлууд хийгдсэн боловч бетон засварын гол ажлууд хийгдээгүй байна. Үүнд гүйцэтгэгч байгууллагаас агаарын хэм хүйтэрсэн тул бетоны ажлуудыг одоо хийх боломжгүй байна гэсэн тайлбар өгсөн болно.

Гүйцэтгэгч “Боорчи” ХХК-ийн зүгээс үерийн даланг үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах Улсын комисс ажиллуулах хүсэлт гаргасантай холбогдуулан 2016 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ЗТХЯ дээр захиалагч, төсөл хэрэгжүүлэх нэгж, зургийн зохиогч, гүйцэтгэгч нарын хамтарсан хурал зохион байгуулагдах байсан боловч цуцлагдсан учраас Төслийн талбай дээр уулзсан. Тус уулзалтаар талууд харилцан санал солилцсоны үндсэн дээр зураг төсөл зохиогчийн өгсөн үүрэг даалгаврын жагсаалт, хэрэгжүүлэх төлөвлөгөө, график, төсвийн талаар холбогдох баримт бичгүүдийг “Боорчи” ХХК 161/016 тоот бичгээр 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлснийг хянан баталгаажуулж, Зам, тээврийн хөгжлийн яаманд 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 43 тоотор хүргүүлсэн.

Дээрхи хүсэлтийн дагуу 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр үерийн далангийн ажлыг хүлээн авах ЗТХЯ-наас томилогдсон Улсын комиссын бүрэлдэхүүн төслийн талбай дээр ажиллаж үзлэг, шалгалт хийсэн ба комиссын акт, дүгнэлт одоогоор албажиж ирээгүй байна.

4. Захиргааны барилга, Аэродромын засвар үйлчилгээний барилга, Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга

Эдгээр барилгуудын гүйцэтгэгчээр “Ви Эйч энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл Зам, тээврийн яамтай /хуучин нэрээр/ 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 113/14 тоот гэрээ байгуулан энэ оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн төслийн талбайд ажлаа эхлүүлэн гэрээний дагуу 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдөр ажлаа дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байсан боловч 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 40,3%-тай байгаа тул гэрээг сунгах саналыг хүргүүлсэн.

Мөн Зам, тээврийн яам /хуучин нэрээр/ Захиалагчийн хяналт хийлгэхээр Барилгын хөгжлийн төвтэй 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 135 тоот гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу тус төвөөс томилогдсон инженерийн баг захиалагчийн хяналт хийж ажилласан.

2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар эдгээр барилгыг барих ажлын хүрээнд 33,382 м3 газар шорооны ажил, 2,045 м3 төмөр бетон цутгалтын ажил хийгээд байна.

Барилга угсралтын ажил доорх гүйцэтгэлтэй байна.

А. Нисэх буудлын үйлчилгээний барилгын ажил

Төсөвт өртөг: 5 596 161 287 төгрөг.

Ажлын дуусгах хугацаа: 2016.12.20

Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар:

- Газар шорооны ажлын гүйцэтгэл 100%
- Суурийн ажлын гүйцэтгэл 98%,
- Шат довжооны ажил 11%,
- Хучилтын ажлын гүйцэтгэл 79%,
- Шалны ажлын гүйцэтгэл 98%

Б. Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын ажил

Төсөвт өртөг: 4928720735 төгрөг

Ажлын дуусгах хугацаа: 2016.12.20

Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2016 оны 12 дугаар сарын 20 ны байдлаар:

- Газар шорооны болон суурийн ажлын гүйцэтгэл 100%
- Хучилтын ажлын гүйцэтгэл 90%
- Шат довжооны ажлын гүйцэтгэл 4%

В. Захиргааны барилгын ажил

Төсөвт өртөг: 3 445 117 956 төгрөг.

Ажлын дуусгах хугацаа: 2016.12.20

Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2016 оны 12 дугаар сарын 20 ны байдлаар:

- Газар шорооны ажил 100%,
- Суурийн ажлын гүйцэтгэл 91%,
- Хана хамар ханын ажлын гүйцэтгэл 39%,
- Хучилтын ажлын гүйцэтгэл 100%,
- Шат довжооны ажлын гүйцэтгэл 47%,
- Дотор гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэл 2%

2016 оны 11 дүгээр сард эхний санхүүжилт хийгдсэнээр гүйцэтгэгч компани сендвич барилгуудын төмөр хийц, захиргааны барилгын цонхыг барилгын талбайд татан авчирсан бөгөөд металл бүтээцийн угсралтын ажлыг гүйцэтгэж байна.